



Японд




амьдрахад

хэрэг болох банкны

данс ашиглах болон

мөнгө шилжүүлэх

аргын талаар



モンゴル語

Банкны данс нээх

Банкны дансыг банк болон доор дурдсан санхүүгийн бусад байгууллагууд дээр нээх боломжтой.

Банк

Шинкин банк

Зээлийн холбоо


JA банк

JF Marine Bank

Хөдөлмөрийн банк

Данс нээлгэхэд, жишээлбэл дараах зүйл шаардлагатай.


(Шаардагдах зүйл нь санхүүгийн байгууллагаас хамаарч өөр өөр байж болно.)



**Оршин суух карт
Паспорт**



Тамга
(Зарим тохиолдолд гарын үсэг байж болно.)



**Компаний ажилтны үнэмлэх,
эсвэл оюутны үнэмлэх**
(Байхгүй тохиолдолд, компани эсвэл сургуулийн хүнээ дагуулан банк руу яваарай.)

Санхүүгийн байгууллагууд өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилгоор ашиглагдахаас урьдчилан сэргийлэхтэй холбогду олон улсын хамтын нийгэмлэгийн уриалга, хуулийн тогтоомжыг дагаж мөрдөх ёстой. Үүнээс үүдэн, банкны данс нээлгэх үед, мөн данс нээлгэсний дараа шаардлагатай тохиолдолд, хэрэглэгчийн мэдээллийг (хаяг, нэр, оршин суух хугацаа / статус, ажиллах нөхцөл гэх мэт) шалгадаг. Хэрэв үүнийг зөвшөөрөхгүй бол данс үүсгэх эсвэл ашиглах боломжгүй болж магадгүй юм.

Үйлчлүүлдэг санхүүгийн байгууллагынхаа дебит картыг гаргуулвал, дэлгүүрт, интернетээр төлбөр хийхэд хэрэглэх боломжтой.

Цалин
банкны
дансанд
орно.

Цалин

Цахилгаан,
хий, ус, утасныхаа
төлбөрийг
данснаасаа төлөх
боломжтой.

Автоматаар
төлбөр хийх

Дэлгүүрт,
интернетээр
төлбөр хийх

Банкны данс нээх
Банкны данс хаах

BANK

ATM


Дараах тохиолдлуудад банкны данс нээсэн газар руугаа холбоо барьж, мэдэгдэнэ үү. Үүнд:

✓ Оршин суугаа хаяг болон оршин суух эрхийн хугацаа / оршин суух эрхийн статус өөрчлөгдсөн тохиолдол

✓ Ажлаасаа, сургуулиасаа гарсан тохиолдол

✓ Банкны дэвтэр болон банкны картаа гээж үрэгдүүлсэн тохиолдол

✓ Нутаг буцах тохиолдол (Банкны дансаа хаана уу.)



Гадаад руу мөнгө шилжүүлэх



- ▶ Мөнгө шилжүүлэх зорилгыг мэдүүлэх материал шаардагдах тохиолдол байна.
- ▶ Мөнгө хүлээж авах талд бэлэн болтол хугацаа орох тохиолдол байна.

Санхүүгийн Үйлчилгээний Агентлагаас хүлээн зөвшөөрөгдөөгүй банк, мөнгө шилжүүлэх үйлчилгээний ААН нь хууль бус учраас, үйлчлүүлэхээс татгалзана уу. Банк, мөнгө шилжүүлэх үйлчилгээний ААН-үүдийн жагсаалтыг Санхүүгийн Үйлчилгээний Агентлагийн вебсайтаас харах боломжтой.

(дараах 2D кодоор нэвтрэх боломжтой.)

Гадаад руу мөнгө шилжүүлэх боломжтой эсэхийн тухайд, мөнгө шилжүүлэх боломжтой орон, бүс нутаг нь банк, мөнгө шилжүүлэх үйлчилгээний ААН тус бүрээс хамааран харилцан адилгүй. Дэлгэрэнгүй мэдээллийн талаар банк, мөнгө шилжүүлэх үйлчилгээний ААН тус бүрээс лавлаж тодруулна уу.







Мөнгө угаах (гэмт хэргийн шинжтэй мөнгө эзэмшигч хувь хүн болон хуулийн этгээдийн мэдээллийг нуун дарагдуулах) нь **хууль бус** юм.



Энэ мөнгийг банкны данснаасаа шилжүүлээд өгөөч. Шанд нь 10,000 иен өгье.



Банкны данс ашиглах болон гадаад руу мөнгө шилжүүлэхтэй холбоотой ямар нэг асуудал гарвал, компани эсвэл сургуулийнхаа хүнтэй зөвлөөрэй.



Хууль бус аж ахуйн нэгж эсэхэд эргэлзэж буй тохиолдолд, тухайн аж ахуйн нэгжээр үйлчлүүлэхээс татгалзаж, компани эсвэл сургуулийнхаа хүнээс зөвлөөгөө аваарай.



Хэрэв та өөрийн дансаа бусдад ашиглуулах гэх мэт ямар нэгэн хууль бус үйлдэлтэй холбогдсон тохиолдолд Япон улсад үлдэх, Япон улсад дахин ирэх боломжгүй болно.

(2024 оны 9-р сард шинэчлэгдсэн)

Японы Санхүүгийн Үйлчилгээний Агентлагийн хаяг

(Үйлчилгээний цаг: Даваа - Баасан 10:00-17:00)

Санхүүгийн үйлчилгээ авах үйлчлүүлэгчдэд зөвлөгөө өгөх алба

0570-016811 (IP утаснаас ярих тохиолдолд 03-5251-6811)

* Бид монгол хэл дээр зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлдэггүй тул япон хэл мэддэг хүнээр дамжуулан бидэнтэй холбоо барина уу.

Англи хэл дээр үйлчлэх нэг цонхны үйлчилгээ

Цахим хаяг: equestion@fsa.go.jp

